



МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/285

Улаанбаатар хот

“НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх
хэлбэрийг устгах тухай Конвенц”-ийн
Монгол Улсын 11 дүгээр тайлан,
илтгэл боловсруулах тухай


Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 9.8 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан хоорондын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Монгол Улсын 11 дугаар тайлан, илтгэлийг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг гэрээлэн гүйцэтгэх ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Зөвлөх үйлчилгээнд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан хоорондын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 5-д тусгагдсан зардлаас гаргахыг Төрийн захиргаа удирдлагын газар (Д.Мөнгөнтуул)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү ажлын тайланг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Гэр бүлийн бодлогын газар (Ц.Мөнхзул)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Д.Ренчиндорж)-т тус тус даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Л.МӨНХЗУЛ

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын
яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025
оны 10 дугаар сарын 24-ны өдрийн № 1285
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЖЛЫН УДИРДАМЖ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улс Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцод 1981 онд нэгдэн орсон билээ. Гишүүн орон энэхүү конвенцын заалтыг хэрэгжүүлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор, түүний дараа дөрвөн жил тутамд болон шаардсан тухай бүр хүргүүлж байх үүрэгтэй байдаг.

Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах конвенцын Хороо 1982 онд Монгол Улсын 1 дүгээр, 1986 онд 2 дугаар, 1999 онд 3-4 дүгээр, 2008 онд 5-7 дугаар, 2016 онд Монгол Улсын ээлжит 8 ба 9 дүгээр, Ковид 19 цар тахлын улмаас 2022 оны 06 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд 10 дугаар тайлан илтгэлийг цахимаар амжилттай хэлэлцүүлэн хамгаалсан. Конвенцийн зөвлөмжийн 23(a), (d), 27 (a), 29 (c) тусгайлсан арга хэмжээний тайланг 2024 онд боловсруулж хүргүүлсэн.

Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 10 дугаар тайланд Хорооноос 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдөр ГХЯ-аар дамжуулж, уг конвенцын зөвлөмжийг ирүүлсэн. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэх салбар дундын ажлын хэсгийг ХНХС-ын 2022 оны 12 сарын 22-ны өдрийн А/211 дүгээр тушаалаар, дахин шинэчилж 2025 оны 10 дугаар сарын 01-ний А/188 дугаар тугаалаар байгуулж, ХНХС-ын 2024 оны 05 дугаар сарын 08-ны А/101 тушаалаар 2024-2026 онд конвенцийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг баталсан.

Тус төлөвлөгөөгөөр үүрэг хүлээсэн талууд төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлын тайланг 2020-2025 оны байдлаар салбарын хэмжээнд боловсруулж 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр манай яаманд ирүүлэхээр ГБХНХЯ-аас бүх оролцогч талуудад албан бичиг хүргүүлээд байна.

ХОЁР. ЗОРИЛГО:

Монгол Улсын ээлжит 11 дүгээр тайлан илтгэлийн төслийг боловсруулах, 2026 оны 07 дугаар сард Конвенцийн хороонд тайланг хамгаалах бэлтгэл ажлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

Зөвлөх нь дараах ажлыг гүйцэтгэнэ.

- Салбар дундын уялдаа холбоог ханган ажиллах;
- Тайлангийн бүтцийг боловсруулах, тайланд тусгагдаагүй холбогдох материалыг бүрдүүлэх;
- Шалгуур үзүүлэлтүүдийг урьдчилан боловсруулж, салбаруудаас статистик үзүүлэлт, дата мэдээллийг цуглуулах маягт боловсруулж мэдээллийг авах, ирүүлсэн дата мэдээлэлд дүн шинжилгээ хийж тайланг боловсруулахад ашиглах;

- Конвенцийн илтгэл боловсруулахтай холбоотой хэлэлцүүлэг, ажлын хэсгийн хурал, уулзалт, сургалт хамтран зохион байгуулах;
- Монгол Улсын ээлжит 11 дүгээр тайлан, илтгэлийн төслийг эцэслэн боловсруулах;
- Конвенцийн хороонд 11 дүгээр тайлан илтгэлийг хамгаалах шат хүртэл ГБХНХЯ-тай хамтран ажиллаж дэмлэг үзүүлэх;

ГУРАВ. ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ БҮТЭЭГДЭХҮҮН:

Тайлан болон бүх материалыг хэвлэмэл байдлаар болон электрон файлаар хүлээлгэн өгнө.

ДӨРӨВ. ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зөвлөх ганцаараа болон 2 хүний бүрэлдэхүүнтэй энэхүү үйлчилгээг үзүүлэхээр оролцож болох ба дор дурдсан чиглэлээр мэргэшсэн байна:

1) Боловсрол:

- 1) Жендэр, хүн ам, гэр бүл, нийгэм, хууль эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй.
- 2) Жендэр, хүн ам, гэр бүл, нийгмийн хөгжил, хамгааллын чиглэлээр мэргэшсэн.

2) Туршлага:

- 1) Жендэр, гэр бүл, хүн амын бүлгүүд, жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлаар бодлого, хууль, хөтөлбөр боловсруулсан туршлагатай;
- 2) Дээр дурдсан асуудлаар судалгаа, шинжилгээ хийж байсан, зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай;
- 3) Жендэр, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр бодлого боловсруулах ажилд оролцож байсан болон НҮБ-ын гэрээ конвенцийн тайлан боловсруулж байсан туршлагатай бол давуу тал болно.
- 4) Шалгуур үзүүлэлт боловсруулах, өгөгдөл- мэдээлэл цуглуулах, шинжлэх, боловсруулах ажлын туршлагатай;
- 5) Дүн шинжилгээний баримт бичиг, тайлан, илтгэл бэлтгэх, илтгэх чадвартай
- 6) Баримт бичиг боловсруулах чадвартай;

3) Мэргэжлийн ур чадвар:

- 1) Салбар дундын уялдаа холбоог хангах, харилцааны өндөр түвшний соёлтой;
- 2) Баримт бичиг боловсруулахад шаардлагатай судалгаа, статистик мэдээлэл, дүн шинжилгээ, тооцоог бие даан хийж, дүгнэлт гаргах, тайланд тусгагдаагүй холбогдох материалыг бүрдүүлэх;
- 3) Ажлын хэсгийн уулзалт, хэлэлцүүлэг чиглүүлэх, зохион байгуулах чадвартай.
- 4) Компьютерын хэрэглээний програмууд болон интернетийн орчинд чөлөөтэй ажиллах;
- 5) Богино хугацаанд ачаалалтай, бие даан ажиллах, хувийн зохион байгуулалт сайтай байх;
- 6) Захиалагч талтай багаар ажиллах, мэдлэгээ хуваалцах, шаардлагатай мэдээллээр хангах, тайлан илтгэл боловсруулах явцад арга зүйгээр хангах, сургах
- 7) Холбогдох салбарт ашиг сонирхлын зөрчилгүй байх.

4) Хэлний мэдлэг, ур чадвар

- 1) Англи хэлийг мэргэжлийн чиглэлээр хэрэглэх түвшинд хангалттай сайн эзэмшсэн.

ТАВ.БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- 1) Уг ажлыг хийх сонирхлыг илэрхийлсэн хүсэлт
- 2) Хүсэлт гаргагчийн товч танилцуулга
- 3) Хүсэлт гаргагчийн мэргэжил, мэргэшил, мэдлэгийг нотлохуйц баримтууд. Үүнд: диплом, сертификат, гэрчилгээний хуулбар
- 4) Зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэх “Ажил гүйцэтгэх төлөвлөгөө болон календарчилсан төлөвлөгөө” боловсруулж, танилцуулах
- 5) Захиалагч байгууллагад нийлүүлэх бүтээгдэхүүнүүдийг бүрэн хүлээлгэн өгсөн ч шаардлагатай үед (конвенцийн хорооноос нэмэлт тодруулга шаардсан тохиолдолд) хамтран ажиллана.

ЗУРГАА. ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛТ

- 1) Ажил гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг боловсруулж захиалагчаар батлуулна.
- 2) Ажлын хэсгийн хурал, уулзалтад тогтмол оролцох, шаардлагатай мэдээллийг ажлын хэсгийн гишүүдээс багаар болон ганцаарчилан ажиллаж гаргуулж авах, ажлын хэсгийг мэдээллээр хангах, тусдаа уулзалтууд хийхдээ ГБХНХЯ, НҮБ-ын ХАС-ын төлөөлөл оруулна.
- 3) ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газрын удирдлага, асуудал хариуцсан албан тушаалтантай байнга холбоотой хамтран ажиллана.
- 4) ГБХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын газрын дарга, тус газрын холбогдох мэргэжилтнүүд нь зөвлөхийн ажлын гүйцэтгэлийн явц, үйл ажиллагаанд хяналт тавина.
- 5) Ажлын явцын тайлан болон хүлээлгэн өгөх бүтээгдэхүүнийг төлөвлөгөөний дагуу захиалагч талд танилцуулж, эцэслэн гэрээт хугацаа дууссанаас хойш 7 хоногийн дотор хүлээлгэн өгнө.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 1) 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд ГБХНХЯ-тай хамтран ажиллана.
- 2) Захиалагч байгууллагад нийлүүлэх бүтээгдэхүүнүүдийг бүрэн хүлээлгэн өгсөн ч шаардлагатай үед /конвенцийн хорооноос нэмэлт тодруулга шаардсан тохиолдолд/ хамтран ажиллана.

ТӨСӨВ. (10.0) сая төгрөг

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРИЛГА

НҮБ-ЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ КОНВЕНЦИЙН МОНГОЛ УЛСЫН 11 ДУГААР ТАЙЛАН, ИЛТГЭЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн Монгол Улсын 11 дугаар тайлан, илтгэлийг боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах тул зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй баг, иргэнийг 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 14:00 цагаас өмнө материалаа ирүүлэхийг урьж байна.

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Жендэр, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр бодлого боловсруулах ажилд оролцож байсан болон НҮБ-ын гэрээ конвенцийн тайлан боловсруулж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Жендэр, эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр ажилласан туршлагатай;
- Шалгуур үзүүлэлт боловсруулах, өгөгдөл- мэдээлэл цуглуулах, шинжлэх, боловсруулах ажлын туршлагатай;
- Дүн шинжилгээний баримт бичиг, тайлан, илтгэл бэлтгэх, илтгэх чадвартай
- Баримт бичиг боловсруулах чадвартай;
- Ажлын хэсгийн уулзалт, хэлэлцүүлэг чиглүүлэх, зохион байгуулах чадвартай.

БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

- Ажил гүйцэтгэгчийн анкет, (баг бол багийн гишүүн бүр);
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Диплом болон холбогдох гэрчилгээний хуулбар;
- Туршлагыг нотлох сургалт арга хэмжээний танилцуулга;
- Албан хүсэлт;
- Ур чадварыг үнэлэх нэмэлт баримт бичиг.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй иргэдийн материалыг 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 14:00 цаг хүртэл хүлээн авах тул Odontsetseg@mflsp.gov.mn цахим шуудангаар эсхүл Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны байранд цаасаар ирүүлнэ үү. Холбоо барих:51-262453

Ажил гүйцэтгэх ажлын удирдамжийг хавсралтаас татаж авна уу.